

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 7
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8 - 28
1.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийг бүртгэх тухай/</i>	8 – 12
2.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай/</i>	12 – 13
3.	<i>Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	13 – 17
4.	<i>“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	17 – 28

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих нийт 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 30 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Ж.Баясгалан;
Чөлөөтэй: Д.Батбаяр, Ж.Ганбаатар, Б.Заяабал, Б.Мөнхсоёл,
П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг.*

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийг бүртгэх тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчдийг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигч Б.Ариунболдыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 12
Бүгд: 13
7.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигч Ц.Бархасыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Чойжилсүрэн, З.Мэндсайхан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигч Л.Батзоригийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 11
Бүгд: 14
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигч Б.Зундуйг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 10
Бүгд: 14
28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасны дагуу Төсвийн байнгын хорооноос Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр Ц.Бархасыг нэр дэвшүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 14

71.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хамтын ажиллагааны хэлтсийн менежер Т.Төрбадрах, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын газрын дарга Э.Нямдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх А.Мандуул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Г.Манлайжав, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Өнөрнасан, “Мон-Атом” ХХК-ийн ахлах геологич А.Алтанхундага, Олон улсын харилцааны судлаач, профессор Д.Баярхүү, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр, Дотоод хуулийн зөвлөх Г.Мөнхболд, Б.Батмандах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх

газрын дарга Н.Учрал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 50 минут үргэлжилж, ирвэл зохих нийт 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 30 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны ирц 52.0 хувь, ирвэл зохих 25 гишүүнээс 13 ирсэн байгаа учраас хуралдааныг эхлүүлье.

Та бүхэнд хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Санхүүгийн зохицуулах хорооны гишүүд нэр дэвшүүлэх асуудал.

Хоёрдугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл.

Гуравдугаарт, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Анхны хэлэлцүүлэг.

Дөрөвдүгээрт, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Анхны хэлэлцүүлэг. Ийм 4 асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эхнийхээ асуудалд оръё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Нэр дэвшигчийг бүртгэх тухай/

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус хүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцье.

Өмнө нь хэлэлцээд олонхын санал 4 хүн аль нь ч авч чадаагүй учраас дахиж зарлаад, тэгээд дахиад нэр дэвшүүлэлт явагдаж байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2 дахь хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус нэг гишүүнийг Төсвийн байнгын хороонд нэр дэвшүүлэхээр заасны дагуу бид өмнө 2024 оны 12 сарын 26-ны өдрийн хуралдаанаар “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталж, сонгон шалгаруулалтын зарыг нийтэд хүргүүлсэн.

Материалыг 2024 оны 12 сарын 30-ны өдрийн 17.00 цаг хүртэл Төсвийн байнгын хорооны 213 тоот өрөөнд хүлээж авсан байгаа.

Төрийн ордны шуудан бичгээр, цахимаар, мөн Их Хурлын гишүүн бас Байнгын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй байгаа.

Ингээд энэ хугацаанд нэр дэвшихийн хүсэлт ирүүлсэн 6 хүний материалыг Та бүхэнд цахимаар болон цаасаар хүргүүлсэн байгаа.

Нэр дэвшихээр 6 материал ирүүлсэн нь иргэн Г.Алтансүх, Б.Батбаяр нарын материал журмын дагуу бүрдэл дутуу, мөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй тул санал хураалтад оролцох боломжгүй гэж үзлээ.

Шаардлага хангасан 4 материалаас Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус нэг гишүүн нэр дэвшүүлэхдээ Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 111.6-д нэр дэвшигч бүрээр санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшүүлж, санал авсан хүнийг нэр дэвшсэнд тооцохоор байгаа.

Энэ журмын дагуу санал хураалт явна.

Өмнөх санал хураалтаар олонхын санал авсан нэр дэвшигч гарч ирээгүй.

Тийм учраас би Та бүхэнд урьдчилан сануулъя.

Олонхын санал авч байж нэр дэвших эрхээ авах юм. Тэгээд цагаан толгойн үсгийн дарааллын дагуу би танилцуулъя.

Б.Ариунболд. 1989 онд төрсөн. 35 настай.

ШУТИС-ийн Компьютерийн техник, менежментийн сургуулийн бизнесийн удирдлагын бакалавр.

Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн бизнесийн удирдлагын магистр, хүний нөөцийн менежмент мэргэжилтэй.

2012 онд “Нэйшнл инженеринг групп” ХХК, “УБ транс” ХХК-д хүний нөөцийн ажилтан, үйл ажиллагаа хариуцсан менежер.

2013-2014 онд “Фаст рооф” ХХК-д гүйцэтгэх захирал,
2017-2020 онд “Хас” банкинд хувийн банкир, мэргэжилтэн, шинжээч,
2021 онд Хөгжлийн банкны төслийн санхүүжилтийн судалгааны захирал,
2020-2024 онд “Эй кэй энд икс финанс” ХХК-д гүйцэтгэх захирлаараар
ажиллаж байсан байна.

Хоёр дахь нэр дэвшигч Ц.Бархас. 1989 онд төрсөн. 35 настай.

Санхүү, эдийн засгийн их сургуулийн эдийн засгийн бакалавр. Виржинагийн
Олон улсын их сургуулийн бизнесийн удирдлагын магистр. Эдийн засагч
мэргэжилтэй.

2015-2016 онд Голомт банкны менежер, нарийн бичгийн дарга.
2016-2020 онд “Таванбогд” ХХК-д ахлах менежер, албаны дарга, ерөнхий
менежер,

2021 онд “Ард санхүүгийн нэгдэл” ХК-д маркетинг хариуцсан захирал,
2022-2024 онд “Ард секюритиз” үнэт цаасны компанид гүйцэтгэх захирал,
2024 оноос “Централ коммерс” ХХК-д захирлаар ажиллаж байна.

Гурав дахь нэр дэвшигч Л.Батзориг. 1988 онд төрсөн. 36 настай.

Санхүү, эдийн засгийн их сургуулийн эдийн засгийн бакалавр. Шихихутаг их
сургуулийн эрх зүйн бакалавр. Санхүүгийн менежмент, эрх зүйч мэргэжилтэй.

2009-2019 онд Худалдаа, хөгжлийн банкны эдийн засаг, салбарын захирлын
үүрэг гүйцэтгэгч,

2022 онд “Мод хөтөлбөр” ХХК-д гүйцэтгэх захирал,
2011 оноос “Ар анд түнш” ХХК-д захиралаар ажиллаж байна.

Дөрөв дэх нэр дэвшигч Б.Зундуй. 1990 онд төрсөн. 25 настай. Санхүүч
мэргэжилтэй.

2012 онд “Хас” банкинд харилцааны менежер.
2012-2016 онд Барилгын хөгжлийн төвд мэргэжилтэн,
2016-2017 онд “Эм Жи Эл интернэйшнл” ХХК-д гүйцэтгэх захирал,
2021-2022 онд Оюу Толгой төсөл, “СААДИ” группийн гэрээ, санхүүгийн
менежер,

2022-2023 онд “БИД” санхүүгийн группт газрын захирал,
2024 оноос “Есөн шижир инвест” банк бус санхүүгийн байгууллагад
Стратеги, хөрөнгө оруулалт хариуцсан захирлаар ажиллаж байна.

Ингээд би та бүхэнд 4 нэр дэвшигчийг танилцууллаа.

Тэгээд цагаан толгойн үсгийн дарааллын дагуу санал хураалтыг явуулъя.

Эхний нэр дэвшигч Б.Ариунболдыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

13 гишүүн санал хураалтад оролцож, 1 хүн дэмжиж, 7.7 хувиар энэ хүн дэмжигдсэнгүй.

Хоёр дахь нэр дэвшигч Ц.Бархасыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

53 хувьтай олонхын санал авч чадаагүй байна шүү.

Б.Чойжилсүрэн гишүүн. Олонхын санал авсан юм байна. Б.Чойжилсүрэн яах гэж байгаа юм?

Б.Чойжилсүрэн: Ц.Даваасүрэн дарга аа, энэ санал хураах төхөөрөмж гацаад байна. Хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Би дэмжсэн.

Ц.Даваасүрэн: Сая олонхын санал авчихсан байна шүү дээ.

Б.Чойжилсүрэн: Би дэмжсэн шүү.

Ц.Даваасүрэн: 53.8 олонхын санал авсан байна шүү дээ.

Тэгвэл дэмжсэн улсуудыг протоколд авлаа. Ж.Батжаргал гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, З.Мэндсайхан бас байгаа юм уу. З.Мэндсайхан гишүүн дэмжсэн юм уу. Дэмжсэн юм байна.

Ингээд энэ 3 гишүүнийг дэмжсэнээр протоколд авлаа.

Ингээд Ц.Бархас олонхын санал авсан учраас дараагийн гишүүдээр санал хураалт явуулах шаардлагагүй болж байна.

Гишүүд ээ, байж байгаарай. Хураасан нь дээр юм байна.

Дараагийн нэр дэвшигч Л.Батзоригийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшигч дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

14 гишүүнээс 3 дэмжиж, 21.4 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийн нэр дэвшигч Б.Зундуйг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

14 гишүүн санал хураалтад оролцож 4 гишүүн дэмжиж, 28.6 хувиар дэмжигдсэнгүй.

Санал хураалт явуулж дууслаа.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус нэг гишүүн Төсвийн байнгын хорооноос Ц.Бархасыг нэр дэвшүүлэхээр хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэлээ. /алх цохив/

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай/

Хоёр дахь асуудалдаа оръё.

Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудал.

Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонголлын тов тогтоох, сонгол даргалагчийг сонгох тухай 07 тоот тогтоолыг баталсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131.1-д Байнгын хороо нэр дэвшигчийг сонгох ажиллагааг явуулснаас хойш 14-өөс доошгүй хоногийн хугацаанд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг цахимаар, эсвэл шуудангаар хүлээн авна гэж заасны дагуу дээрх “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулж Та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Гишүүлт асуулт асууж, үг хэлж дууслаа.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 14 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 71.4 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

**Гурав.Үндэсний баялгийн сангийн тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**
/Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Гурав дахь асуудалдаа оръё.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 3 зүйлтэй. Зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг Та бүхэнд танилцуулъя. Ажлын хэсгийг оруулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яам, Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Гүнсэнсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Хууль эрх зүйн зөвлөлийн дарга, Цэдэнбалжирын Төгсбуян “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Лувсаншаравын Наранчимэг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Түмэнжаргалын Төрбадрах “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хамтын ажиллагааны хэлтсийн менежер, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын газрын дарга гэсэн ийм хүмүүс оролцож байна.

Зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Байгаа юм уу? Ж.Батжаргал гишүүн байна. Ж.Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Төрийн эзэмшлийн хувьцааг орлуулж болох тухай бид эрх зүйн хувьд нээгээд өгчихсөн.

Тэгээд түүнээс орж ирэх орлогоос хуримтлалын сандаа төвлөрүүлэх тухай асуудал яригдаад байгаа юм.

Тэгэхээр 11.1.2-ын “б” заалт, 11.1.2-ын “б” заалттайгаа яаж холбогдох вэ гэдэг асуудал байгаад байна л даа. Төрийн хөрөнгөөр хайгуул хийгдчихсэн стратегийн ордын 50 хүртэл хувийг эзэмших тухай асуудал, түүнээс орж ирэх ногдол ашгийн 34 хувьтай тэнцэх эсэхийг нь хуримтлалын сандаа оруулах тухай асуудлыг бид Баялгийн сангийн тухай хуулийнхаа 11.1.2-ын “б”-гээрээ зааж өгсөн. Гэтэл 11.1.2-ын “в” болохоор зэрэг тэр ногдол ашгийг тэр чигт нь хуримтлалын сан руу оруулахаар уншигдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хоёр хоорондоо яаж холбогдоод байна вэ? Хуульд заасан хувь хэмжээгээрээ орох юм биш үү? Энэ дээр төсөл өргөн баригч нэг тайлбар өгмөөр байна.

Ц.Даваасүрэн: Хэн хариулах вэ? Сайд нар нь яасан юм бэ дээ. Уг нь Байнгын хороо, чуулган дээр улс төрийн албан тушаалтан хариулах хуультай юм шүү дээ.

Сангийн яамнаас хариулах хүн байна уу? Хэн хариулах юм? Тэр нөөцийн төлбөр. 6 номерын микрофон. Нэрээ хэлээд тэгээд асуултад хариулъя.

Б.Гэрлээ. “Эрдэнэс Монгол” компанийн Хууль эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ.

Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1-ийн “б” болон “в”-д.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу “б”-д нь 34 хүртэлх хувийг нь шууд төвлөрүүлэх байгаа. Тэр нь болохоор төрийн эзэмшлийн яг 34 хүртэлх хувийн ногдол ашгийг нь шууд төвлөрүүлэхээр.

“В” нь болохоор тэр 50 болон 34 хүртэлх тогтоогдсон хэмжээгээр роялтигаар сольсон нөхцөлд тэрийгээ дахиад Үндэсний баялгийн сан руу төвлөрүүлэхээр тэр зохицуулалт нь л орж ирж байгаа. Давхардсан зохицуулалт бол биш.

Ц.Даваасүрэн: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Үгүй ээ, үгүй. Наадах чинь ийм заалт болчхоод байна л даа.

Бид 50 хүртэл хувьтай стратегийн орд байвал тогтоогдсон хувь хэмжээгээ тэр авах ёстой. Гэтэл тэр тогтоосон хувь хэмжээний чинь 34 нь хуримтлалын сан руугаа орох ёстой байхгүй юу.

Гэтэл одоо та хэдийн орж ирчхээд байгаа “в” заалт чинь яг тэр нийт хувьцаа чинь хуримтлалын сан руугаа орох гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энд хуулиар тогтоосон хувь хэмжээ гэдэг үгээр хуулийнхаа энэ заалтын зохицуулалтыг хийж өгөхгүй бол энэ чинь Байнгын мөрдөгдөх хуулийн заалт шүү дээ. Зөвхөн өнөөдрийн ярьж байгаа энэ кэйс дээр биш.

Тийм учраас эрх зүйн хуулийн заалт хоорондын зөрчил үүсээд байна уу гэдэг л асуудал гарч ирээд байгаа юм.

Ц.Даваасүрэн: Энэ дээр хариулах хүн байна уу? Хуулийн зөрчил үүсээд байна гээд байна шүү дээ. Б.Тэлмүүн хариулах юм уу? 8 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яам Б.Тэлмүүн Ж.Батжаргал гишүүний асуултад хариулъя.

11.1.2-ын “а”, “б” дээр 34 хүртэл хувь эзэмшиж байгаа бол бүх ногдол ашиг, 34-өөс дээш бол 34 хувьтай тэнцэх буюу ер нь 34 хувийнх нь ногдол ашгийг хуримтлалын сан руу авна гэж байгаа.

Энэ оруулж байгаа төслийн хувьд 34 хувийг орлуулахтай холбоотой энэ өгөөжийг бид тусгаар роялти болон энэ өгөөж тогтворжуулах энэ төлбөрөөр орлуулж байгаа.

Тэгэхээр энэ бол цаад агуулгаараа 34 хувийн хувьцаа эзэмшилтэй холбоотойгоор авч байгаа өгөөж гэсэн агуулгаар.

Тэгэхээр энэ дээр хуулийн зөрчил үүсэхгүй. Тэгэхээр ингэж явж байгаа.

Ц.Даваасүрэн: Асуулт асууж дууслаа.

1 дүгээр зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Ж.Батжаргал гишүүн зарчмын зөрүүтэй санал байгаа юм уу, байхгүй юу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? 2 дугаар зүйл дээр. Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? 3 дугаар зүйлээр. Алга байна. /алх цохив/

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл тус бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Одоо Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье. 4 зүйлтэй байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

1 дүгээр зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

2 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Ж.Батжаргал гишүүн асуултаа асууя. Ж.Батжаргал гишүүн шиг идэвхтэй бай.

Ж.Батжаргал: Энэ Ашигт малтмалын тухай хуулийн 47-гийн штрих 2.2 дээр нь Засгийн газарт хувь хэмжээ тогтоохоор заалт байгаа юм. Тэрийг хүчингүй болгосон тийм зохицуулалт ерөөсөө байхгүй.

Тэгэхээр одоо бид хэд энэ 47-гийн штрих 2.2 дээрээ Их Хурал тогтооно гээд оруулаад ирчихээр зэрэг уг заалт дээр нэмэлт, өөрчлөлт орчихлоо гэж ойлгогдоод явчих ёстой юу? Тийм үү? Тэгж ойлгож болж байна уу?

Ц.Даваасүрэн Хариултын протоколд авъя. 6 номерын микрофон.

Б.Гэрлээ: Энэ бол Засгийн газарт байсан эрхийг Улсын Их Хурал руу, Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоохоор өөрчлөн найруулж байгаа.

Тэгэхээр тэгж ойлгож болно.

Ц.Даваасүрэн: 3 дугаар зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу?

4 дүгээр зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд танилцуулъя.

Эдийн засгийн байнгын хороонд Р.Батболд гишүүн байгаа. Тийм ээ. Р.Батболд гишүүн танилцуулчихъя. Тэгэх үү? Р.Батболд гишүүн танилцуулъя.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дөрөв. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./

Дөрөв дэх асуудалдаа орьё.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн.

Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Алтангэрэлийн Мандуул Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын дарга, Том татвар төлөгчийн газрын дарга, Зэнээмядарийн Батбаяр Усны газрын дарга, Гун-Аажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга, Лхасүрэнгийн Жаргалсайхан Шинжлэх ухаан академийн Хими, хими технологийн хүрээлэнгийн захирал, Цагааны Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Амарсанаагийн Алтанхундага “Мон-Атом” ХХК-ийн ахлах геологич,

Дашдоржийн Баярхүү Олон улсын харилцааны судлаач, профессор, Норовын Тэгшбаяр Физикийн ухааны доктор, Ганбатын Мөнхболд Дотоод хуулийн зөвлөх, Баярбатын Батмандах Дотоод хуулийн зөвлөх гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу?

Ж.Батжаргал гишүүнээр тасаллаа. Ж.Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Тэгэхээр төрийн эзэмшлийн 34 хувийнхаа 10 хувийг нь..

Ц.Даваасүрэн: Сайдуг дуудъя. Н.Учрал сайдыг дуудъя

Ж.Батжаргал: ...давуу эрхийн хувьцаагаар 24 хувийг нь бид ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулахаар эрх зүйн зохицуулалт хийж байгаа юм.

24 хувь нь тусгай төлбөрийн хэдэн хувьтай тэнцэж байгаа юм бэ? Ер нь. 5.6 тэрбум долларын өгөөж бид хүртэнэ гэсэн ерөнхий томьёолол яваад байх шиг байна.

Тэгэхээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр суурь АМНАТ 5 хувь, тусгай төлбөрөөр бид үнэлгээтэй холбогдуулаад тогтоочоод байгаа юм. 5 байж болохоор. Өсөн нэмэгдэх бол зах зээлийнхээ үнэтэй холбоотой гарч ирэх ёстой. 9 гэдэг юм яригдаад байгаа.

Гэхдээ одоо дэлхийн зах зээл дээрх үнэ ер нь 80-аас 100 долларын юутай яваад байгаа юм шиг байгаа юм. Тэр нь 5 хувь. Үндсэндээ 15 хувь байхгүй юу. Гэтэл 19 хувиар ер нь хэзээ ч бараг хүрч болохооргүй хувь ярьцгаагаад байгаа нь хэр зохимжтой юм бэ? Нэг.

Хоёрдугаарт, тэр 24 хувьд ногдох ашиг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тусгай төлбөрийн 5 хувиар орлуулчихад одоо болно гэсэн тийм тооцоолол, судалгаа нь яаж гарч ирээд байна аа? Тэр техник, эдийн засгийн үндэслэл юмнуудаар чинь ер нь яг юу гэж гараад байна аа? Энэ дээр нэг тодорхой хариу авмаар байх юм.

Ц.Даваасүрэн: Уг нь сайд л хариулмаар байх юм. Хэн хариулах вэ?

Хууль санаачлагчдаас хариулах хариуцлагатай улс төрийн албан тушаалтан байна уу? Энэ улс төрийн албан тушаалтан л байх хэрэгтэй байна л

даа энэ чинь. Төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай яриад байгаа шүү дээ. Нөхөд өө.

Ер нь зүгээр Монгол шиг хайгуул хийсэн тэр баялгийг эзэмшиж байгаа хүнээсээ их хувь авдаг улс орон дэлхийд хаана ч байхгүй. Хайж олсныхоо төлөө тэр баялгийг эзэмшиж байгаа улс орноосоо 66 хувиар илүү авдаг орон ганцхан Монгол байна шүү дээ. Би баялгаа гаргалаа 50 хувь гэж бид дуугарч чадахгүй байна шүү дээ. Чи үйлдвэрээ гарга 50 хувь гэж дуугарч чадахгүй байна шүү дээ.

Тийм учраас энэ дээр нэг жоохон хариуцлагатай хандаж байхгүй бол. Одоо Африкийн орнууд хүртэл тийм байна шүү дээ. Ботсвана /Botswana/. Би баялгаа гаргалаа 50 хувь. Чи үйлдвэрээ гарга 50 хувь.

Одоо бүр сүүлдээ хувиа нөөцийн төлбөр лүү оруулаад ингээд хяналт тавьж чадахгүй. Хяналт тавьж чадахгүй болохоор яах вэ, зардлаа өсгөнө. Зардлаа өсгөхөөр яах вэ. Татвар төлөхгүй. Яг л ийм Оюу Толгойн байдал руу орж байна шүү дээ.

Хариулах хүн байна уу? 7 номер юу ч гэсэн хариул даа.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Л.Энх-Амгалан. Гишүүний асуултад хариулъя.

Энэ өгөөжийг 51 хувь хүргэхтэй холбоотой асуудал асуугаад байгаа.

Нийт би ерөнхий тоонуудыг нь хэлж өгье. Нийт ураны үнийг 1 фунтыг нь 80 доллар дээр тооцоо хийж байгаа. Одоохондоо.

Яг зах зээлийн үнэ бол одоо 75 доллартой байгаа. 90 доллар, 100 доллар дөхөөд өнгөрсөн оны сүүлээс эхлээд бууж эхэлсэн. 80 доллар дээр тооцоо хийхэд нийт борлуулалтын орлого нь 14 тэрбум доллар болно. Үүнээс ТЭЗҮ-гийн хамгийн сүүлийн хувилбарыг аваад үзэхэд 4 тэрбум орчим нь зардал болж байгаа юм. Үйл ажиллагааны зардал, борлуулсан бүтээгдэхүүний өртөг энэ тэр.

Тэгээд нийт хувааж болох өгөөж бол 10 тэрбум доллар байна. Түүнээс 5.2 тэрбум долларыг нь Монгол Улсын Засгийн газар татвар болон зарим төлбөрөөр авч байгаа. 4.9 тэрбум долларыг нь хөрөнгө оруулагч тал ногдол ашиг болон ноу хаугийн төлбөр, маркетингийн төлбөрөөр авч байгаа.

Тэгэхдээ хөрөнгө оруулагч тал бол анх оруулсан 500 сая долларын хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа 4.9-ийг авна.

Тэгэхээр манай Засгийн газар яг шууд төсөвт авч байгаа мөнгөн орлогоороо 51 хувьд хүрч байгаа. Одоо.

Хэрвээ энэ үнийн түвшнээс хамаараад 51 хувиас доошоо орсон тохиолдолд тухайн жил болгондоо тийм тохируулагч төлбөр авна гэсэн тийм гэрээний заалттай.

Ерөнхий барьсан юм бол эцэстээ манай улсын Засгийн газар шууд төлбөрөөр 51 хувийг нь авна гэдэг тийм л гэрээг хийсэн байгаа.

Ц.Даваасүрэн: Ер нь ТЭЗҮ нь бол батлагдчихсан юм байна. Тийм үү? Зөвлөлөөр ороод. Тийм үү? Энэ чинь Ашигт малтмалын тухай хуулиар ТЭЗҮ батлагдаж байж хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдана гэж байж байгаа шүү дээ.

Тийм учраас чи бол ТЭЗҮ-гээс ярилаа гэж ойлголоо. Зөв үү? 7 номерын микрофон.

Л.Энх-Амгалан: ТЭЗҮ-гийн хамгийн сүүлийн хувилбараас тоонуудаа авсан. ТЭЗҮ бол Эрдэс баялгийн зөвлөл дээр одоо яг батлагдах шатандаа явж байгаа.

Ц.Даваасүрэн: Тэгээд манай гишүүд чинь ашигтай төсөл байна гээд л яриад л байгаа шүү дээ. Тэгээд ТЭЗҮ-г нь үзээгүй байж юугаа яриад байгаа юм.

Л.Энх-Амгалан: ТЭЗҮ бол Уул уурхайн яаман дээр ирчихсэн, Эрдэс баялгийн зөвлөл дээр ирчихсэн.

Ц.Даваасүрэн: Би бол ТЭЗҮ нь батлагдчихсан гэж ойлгосон шүү дээ.

Л.Энх-Амгалан: Тэрнийг хөрөнгө оруулалтын гэрээ хийж байгаа хүмүүс хамгийн сүүлийн хувилбарийг нь аваад бүх санхүүгийн тооцооллуудаа хийгээд явж байгаа.

Ц.Даваасүрэн: Манай гишүүд чинь ашигтайг нь гайхаад л байгаа шүү дээ.

Тэгэхээр ТЭЗҮ нь гараагүй байхад яаж тэгж мэдээд байдаг юм бол.

Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Үндсэн хуулийн 6.2-оор өгөөжийн дийлэнх хэсэг нь ард түмэнд хуваарилагдах тухай заалтаар Та хэд тайлбар яриад байгаа юм.

Бид хэд бол 24 хувиа тусгай төлбөрт орлуулж байгаа улс байхгүй юу. Тэгээд та хэдийн одоо ярьж байгаа юмнаас чинь харахаар зэрэг тусгай төлбөрөө 5 хувь байхаар хавсралтаар байгаад байна.

Тэгээд 10 тэрбум долларын ер нь ашиг байх юм байна гэж тооцоод байгаа юм бол наадах чинь 500 сая л болчихоод байгаа байхгүй юу. 24 хувиар тооцох юм бол 2.4 тэрбум долларын тухай асуудал байхгүй юу. Ерөнхий багцаа, томсгосон тооцоо харахаар.

Тэр цаад 51 хувийг бусад татваруудаар авах асуудал энд ямар ч хамаагүй. Бид 34 хувиа 10 хувийг нь давуу эрхийн хувьцаагаар, 24 хувийг нь ашигт малтмалын тусгай төлбөрөөр авах гээд байгаа байхгүй юу.

Тэгээд тэр 24 хувь чинь тавтай дүйж байгаа тухай та нар оруулж ирээд байна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь яаж барьж байгаа юм бэ гэдэг тооцоо л яриад байна. Би.

Хоёр өөр тооцооллын зарчмыг нэгтгэж ташаа мэдээлэл өгөөд байдгаа л больчих л доо. 34-өө 10-ыг нь давуу эрхээр авч 24-ийг нь тусгай төлбөрийн 5-аар авъя гэж ярьцаачихлаа. Тэгээд тэр тусгай төлбөрийн 5-д чинь одоо хэдэн тэрбум доллар ноогдоод байгаа юм бэ? Энэ чинь л гол байгаад байна шүү дээ.

Тэгээд та хэд нэг ийм юм яриад байгаа юм. Хэрвээ өгөөж 51-ээс давахаа байчихвал тохируулагч төлбөр авах тухай яриад байгаа. Манай хуульд тохируулагч төлбөрийн тухай ойлголт байхгүй шүү. Та нар ийм юм ярьж байгаа бол ёстой тэр Ашигт малтмалынхаа тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульдаа тэр тохируулагч төлбөрийнхөө эрх зүйн зохицуулалтыг оруулж ирэх ёстой. Тэгж байж наадах чинь баталгаажих ёстой.

Ц.Даваасүрэн: Н.Учрал сайд хариулъя.

Гол санаа нь Үндсэн хуулийн 6.2-оор “баялаг ард түмний” гэдэг энэ заалт тухайн төсөл дээр хэрэгжиж байна уу гэж асуугаад байна.

6 номерын микрофон шүү.

Н.Учрал: Төр эзэмшлийнхээ 34 хувиас шууд татгалзаж байгаа гэсэн ойлголт огт биш. Энэ чинь нөгөө төрийн эзэмшлийн 34 хувийг АМНАТ-аар юм уу, бүтээгдэхүүн хуваахаар орлуулах эрх нь Их Хуралд байгаа учраас энэ хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл дээр л бид орлуулах ийм шийдвэрийг Их Хурлын энэ тогтоолоор албажуулах гэж байгаа.

Тэгэхээр Их Хурлын тогтоол гарвал хөрөнгө оруулалтын энэ гэрээн дээр л 34 хувь нь АМНАТ-аар орлоно л гэсэн үг л дээ.

Тэгэхээр ер нь бол 34-өөсөө шууд татгалзаж байгаа гэж бас хэлэх нь зохимжгүй.

Тэгээд бид юун дээр тохиролцсон бэ гэхээр яах вэ, ер нь бол Үндсэн хуулийн тэр 6.2-ыг хангуулахад л гол анхаарлаа тавьж байгаа юм. Тэр хангуулахад юу юуг Засгийн газрын өгөөж гэж үзэх вэ, юу юуг хөрөнгө оруулагч талынх нь өгөөж гэж үзэх вэ гэдэг дээр тохиролцох гэж нэлээдгүй ажилласан.

Энэ хүрээндээ ер нь 13 татвар, төлбөрийг л яг манай Засгийн газрын өгөөж гэж үзнэ гэж хатуу тавьж өгч байгаа. Энэ дотроо тэр маркетингийн зардал ч гэдэг юм уу, элдэв зардлуудыг өнгөрсөн хугацааныхаа сургамжийг харсан учраас бид тэр Засгийн газрын үр өгөөж дээр нь тооцоогүй. Нөгөө хөрөнгө оруулагч тал үүнийг өөрсдийнх нь өгөөж гэж үзнэ гээд ялгаж байгаа.

Тэгэхээр энэ 13 өгөөжийг нь аваад үзэхээр энэ 50 дээр нэмэх 1 хангагдаж байгаа.

Гэхдээ бүтээгдэхүүнийхээ үнийг зах зээл дээр хэрхэн хэлбэлзэж байгаагаасаа шалтгаалаад зарим тохиолдолд 51 шууд хүрэхгүйгээр 50 зууны дөчин хэд ч гэдэг юм уу. Өнөөдөр 1 фунт ураны үнэ 80 доллар байна гэвэл 50 зууны дөчин гээд гарчхаж байгаа юм.

Өдоо магадгүй ирэх жил тэр нь хэр болдог юм уу, 100 болдог юм уу. Ингээд өсөөд явбал 51 нь даваад явна. Хэрвээ буурвал яах вэ. Буурвал яах вэ гэхээр нөгөө 51-ээ хангуулахгүй бол түүн дээр нь хөрөнгө оруулалтынхаа гэрээнд тэр benefit adjustment_[ашиг тусын тохируулга] гээд байгаа буюу тэр өгөөжийн тохируулга хийнэ гэдэг энэ тохиролцоонд хүрээд, нөгөө хөрөнгө оруулагч тал ашгаасаа шууд манай талд тэр 50 дээр нэмэх нэгийг хангуулах дээр тэр үлдээд байгаа хэсэг дээр нь нөхөж өгнө өө л гэсэн ийм л зарчмыг Хөрөнгө оруулалтынхаа гэрээнд суулгасан.

Яагаад гэхээр Үндсэн хуулийн 6.2-ыг барьж байна л гэсэн үг. Үндсэн хуулийн 6.2-ыг барьж бид санхүүгийн схемийг өөрсдөө боловсруулсан. Энэ дээр санхүүгийн шинжилгээний, хуулийн гээд 3 олон улсын компани дотоодын санхүүгийн шинжилгээний компаниуд оролцоод бид өөрсдийнхөө санхүүгийн моделийг боловсруулаад өөрсдийнхөө схем дээр 50 дээр хэд юм, 60 дээр хэд юм, 70 дээр хэд юм, 80 дээр хэд юм гээд аваад аваад үзэхээр энэ тохиолдолд.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: 6 номерын микрофоныг дахиад өгье. Энэ тохиолдолд яг хэдэн төгрөгийн тохируулга хийгдэх вэ гэдгийг бас тооцоолсон.

Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсанаараа 16 жил үргэлжилнэ гэвэл 16 жилийн хугацаанд өнөөдөр 1 фунт ураны үнэ 80 доллароор бодоод үзвэл зөвхөн өгөөжийн тохируулга дээр 100 сая доллар нөхөж хийнэ гэсэн үг.

Тэгэхээр үүнийгээ хатуу хөрөнгө оруулалтынхаа гэрээнд тусгаад өгсөн.

Тийм учраас зүгээр 50 дээр нэмэх 1 гэдэг зарчмаа бариад бидний санхүүгийн схем дээр нөгөө тал ажилласан гэсэн үг.

Тэгээд бид өөрсдийнхөө санхүүгийн схем дээр суурилсан өөрсдийнхөө хөрөнгө оруулалтын гэрээний драфтыг боловсруулсан. Ингээд манай драфт дээр тэд саналаа өгөөд манай санхүүгийн схем дээр нөгөө бүтээгдэхүүнүүдийнхээ үнийг тавьж байршуулж байгаад ер нь бол 80 орчим байна гэвэл 100 орчим сая доллар бол өгөөжийн тохируулга дээр хийгдэх юм байна гэж ингэж үзэж байгаа.

Тэгээд үнэ 40-өөс доош орчихвол 160-аас дээш байх. Тийм ээ. 170-аас дээш гарчих юм бол хөрөнгө оруулалтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт яригдана. Яагаад гэвэл бүтээгдэхүүний үнэ хэт доошлоод, эсвэл 170-аас хэт их өндөр бол бид дахиж ярих ийм нөхцөл үүснэ.

Түүнээс бусад тохиолдолд бид яг хөрөнгө оруулалтын өгөөжийн тохируулга дээрээ төлбөрөө тооцож шийдсэн гэсэн үг.

Тэгэхээр Үндсэн хуулийн 6.2-оо барьсан санхүүгийн схем учраас өгөөжийн тохируулгыг бол хөрөнгө оруулалтын гэрээндээ тусгаад явж байгаа нь манай Үндсэн хуулийн зарчмыг хангуулахад чиглэгдэж байгаа заалт гэж ойлгох боломжтой.

Тэгээд Баялгийн сангийн хууль гарч байгаа учраас саяын өөрчлөлт орчхож байгаа учраас нөгөө тусгай АМНАТ-ын 5 хувь нь Баялгийн сан руугаа, тэр дотроо өнөөдрийн иргэдийн хуримтлалын сан руу шилжих ийм нөхцөл бүрдэнэ.

Бусад 50 дээр нэмэх 1 нь төсөв рүү, орон нутгийн сан руу, тогтворжуулалтын сан.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Өгөөж гэдэг нь ашгаа хуваахыг хэлээд байна уу? Энэ дээр нэлээн тодруулаад хэлээч.

Тэгэхгүй бол наана чинь байна шүү дээ. Нөгөө Оюу Толгой шиг зардлаа өсгөж явчхаад зардлаараа хамаг юмаа аваад, зээлээрээ хамаг юмаа авчхаад тэгээд хэдхэн долларыг энэ нь 51 хувь гээд суух юм биш биз дээ. Тэрийг та хэд тодруулчхаач.

Ер нь тэгээд энэ ТЭЗҮ батлагдаж байж хөрөнгө оруулалтын гэрээ батлагдах хуультай. Ашигт малтмалын хуулиар.

Тийм учраас Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэхэд гишүүдэд ер нь энэ ТЭЗҮ-гийн танилцуулгыг хийх нь зүйтэй юм байна даа. Тэгж байж итгэл үнэмшилтэй болно. Тэрийг нэг тодруулаадхаач.

Н.Учрал: Тийм. Одоо жишээ нь тэр 13 төлбөр, татвар гээд байгаа дотор жишээ нь агаарын бохирдлын төлбөр ч гэдэг юм уу ороогүй.

Яагаад гэвэл агаарын бохирдлын төлбөр бол Засгийн газрын авч байгаа өгөөж биш. Энэ бол өөрөө агаар бохирдуулсныхаа төлөө эргээд зарцуулж байгаа. Түүнээс биш энэ бол манай аваад байгаа ашиг өгөөж ерөөсөө биш ээ гэж үзэж байгаа.

Өгөөжийг юу гэж ойлгож байна гэхээр мөнгөн дүнгээр манай төсөв рүү баялгийн сан руу орж байгаагаа л бид өгөөж гэж шууд тооцож байгаа. Жишээ нь, Засгийн газрын ногдох шууд үр өгөөж гэхээр АМНАТ, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд ногдох ногдол ашиг буюу нөгөө санхүүгийн хариуцлага хүлээхгүй 10 хувийн ногдол ашиг. Тэгээд дээрээс нь ногдол ашгийн суутган татвар. Нөгөө тал чинь нөгөө ногдол ашгаа авна шүү дээ. Тэндээс нь авч байгаа суутган татвар. Тэгээд гааль, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, орон нутагт оруулах хөрөнгө гээд нөгөө орон нутагт жил бүр сая доллар өгч байгаа. Оруулна.

Дээрээс нь үл хөдлөх хөрөнгийн татвар, тусгай зөвшөөрлийн төлбөр, хүүгийн орлогын суутган татвар. Жишээ нь, тэр чинь нөгөө хамтын компани учраас мэдээж зээл авлаа гэхэд манайх нөгөө 10 хувь дээрээ ямар нэгэн нөгөө Оюу Толгой шиг санхүүгийн хариуцлага огт хүлээхгүй.

Түүн дээрээ бид нөгөө тал одоо жишээ нь зээл авлаа гэхэд тэд нар чинь тэд хариуцлага хүлээх ч гэсэн хүүгийн орлогоос нь суутган татвараа бол манай тал авна. Тэгээд энэ дээр мэдээж өгөөжийг нь тохируулах төлбөр. Тэгээд ийм байдлаар манай тал оруулсан.

Ц.Даваасүрэн: Ийм тодруулга асуугаад байхгүй юу.

Борлуулалт. Борлуулалтаас зардлаа хасаад, тэгээд тэр үлдэж байгаа хэсгээ хуваахыг өгөөч гэж яриад байна уу л гэж асуугаад байна шүү дээ бид. Тийм зардлаа хэт өндөр явсаар байгаад бараг одоо чинь Оюу Толгой чинь борлуулалтаасаа давчхаад байгаа шүү дээ. Ямар ч ашиггүй болчхоод байгаа шүү дээ. Тэгчихвэл ямар өгөөж бий болох вэ л гээд байна л даа. Зардал чинь өндөр болоод явчих юм бол. Зардал чинь борлуулалттайгаа тэнцсэн шахуу юм яриад ингээд одоо алдагдалтайтай ажиллалаа гээд байвал яах вэ? Тийм юм гарах уу?

Н.Учрал: Ер нь яг Ц.Даваасүрэн гишүүний энэ болгоомжлол дээр суурилоод бид тэр 34 хувийг л тусгай АМНАТ-аар орлуулж байгаа юм. Ерөөсөө.

Яагаад вэ гэхээр хэрвээ 34 хувийн ногдол ашгийг шууд эзэмшинэ гэсэн яг наад хэд чинь зардлаа нэмээд л, менежментийн зардлаа ахиулаад л ингээд л ногдол ашиг авах хугацаа хэзээ ирэх нь ойлгомжгүй хугацаа сунгагдаад яваад байх байсан.

Одоо бол яаж байна вэ гэхээр АМНАТ, тусгай АМНАТ, суурь АМНАТ-ын 5, тусгай АМНАТ-ын 5, өсөн нэмэгдэх 10-аас 19 гээд тооцвол энэ АМНАТ шууд борлуулалтаас нь авна. Шууд борлуулалтаас.

Түүнээс биш тэд нарын ашигтай ажиллах, ашиггүй ажиллахаас үл хамаараад борлуулалтаас нь бид 19 хүртэлх хувийг АМНАТ-ыг шууд авна гэсэн үг. Үүн дээр нэмэгдээд саяын 13 янзын төлбөр, татвар нэмэгдэж байгаа.

Тэгэхээр бид ямар ч тохиолдолд тэдний ашигтай ашиггүйгээс үл хамаараад шууд өсөн нэмэгдэх АМНАТ-тайгаа нийлүүлээд борлуулалтаас нь авна.

Түүнээс биш одоо бид тэр 10 хувь дээрээ тэд нар зээл авлаа гэхэд бид ямар нэгэн санхүүгийн хариуцлага хүлээхгүй. Тэд нар төсөл нэмэлтээр хэрэгжүүлэе гэхэд 10 хувь дээр хөрөнгө оруулалт хийхгүй. Ямар ч зардал тэд нар гаргах нь огт хамаа байхгүй.

Ц.Даваасүрэн: Менежмент Пи_[management plan] гэж тэд нар авахгүй юм байгаа биз дээ?

Н.Учрал: Тийм. Менежмент Пи гэж авахгүй.

Ц.Даваасүрэн: Ж.Батжаргал гишүүн дутуу хариулсан учраас хоёр дахь тодруулгаа.

Ж.Батжаргал: Үгүй ээ, үгүй. Тэр 51 хувийн өгөөжийг бол ойлгоод байгаа. Та нар татваруудаа нэмээд, дээр нь ногдол ашгаа нэмээд ингээд 51 хувийн тухай яриад байгаа юм. Би тэрийг ойлгоод байгаа.

Гэтэл татварын дараах ашгийн 34 хувь бидэнд ногдох байхгүй юу. Түүнийхээ 10-ыг давуу эрхтэй хувьцаагаар авч байгаа. 24 хувийг нь тусгай АМНАТ-аар авна гээд яриад байгаа улс байхгүй юу бид.

Гэтэл 24 хувийн тэр ногдол ашиг чинь тусгай АМНАТ-ын 5 хувьтайгаа яг дүйж байгаа юм уу гэдэг л асуудал байгаад байгаа байхгүй юу. Хамгийн гол зүйл. Ойлгож байгаа биз дээ. Үгүй ээ, тэгээд та хэдийн ярьснаар тооцоолол хийгээд үзэхээр зэрэг.

Ц.Даваасүрэн: Ж.Батжаргал гишүүн дараа нь та нар бас тэр тооцооллоо үзүүл. Тэр ТЭЗҮ гарсан байгаа бол түүнийгээ үзүүл.

Б.Тэлмүүн: Сангийн яам. Б.Тэлмүүн.

Ж.Батжаргал гишүүний асуултад нэмж хариулъя.

Яг таны санаа зовж байгаа асуудлыг бид нарын хувьд хамгийн чухал асуудал байсан. Энэ дээр хоёр асуудал байгаа.

Нэгдүгээрт, 34 хувийн үр өгөөжийг бид ногдол ашиг хэлбэрээр авах юм уу, АМНАТ-аар авах юм уу гэдэг асуудал байсан. Энэ бол эхний протокол зурагдах үед хамгийн гол яригдсан асуудал.

Ажлын хэсгийн зүгээс хоёр асуудлыг анхаарч байгаа.

Нэгдүгээрт, аль орлогын өгөөжийн урсгал нь илүү найдвартай юм бэ. Бид алинд нь илүү түшиглэсэн санхүүгийн модель загвараа сонгох ёстой юм бэ гэдэг нэг асуудал.

Хоёрдугаарт нь, яг АМНАТ-аар. Энэ эхний асуудлын хувьд бид Оюу Толгойн сургамж, өмнөх Улсын Их Хурал дээр гарсан маш олон ажлын хэсгийн үр дүнд зардалд суурилсан буюу бид зардлын дараах цэвэр ашгаас өгөөж хүртэх энэ хувилбар бол эрсдэлтэй.

Ийм учраас бид АМНАТ буюу хамгийн эрсдэлгүй татварынхаа энэ орлогыг хамгийн өндөр байлгахад хэлэлцээр хийхэд орсон.

Энэ хүрээндээ 34 хувийг 10 хувь болгож орлуулахтай холбоотой хэлэлцээр зөвхөн 5 хувь дээр яригдаагүй. Энэ хэлцэл тусгаар роялти 5 дээр нэмэх нь өсөн нэмэгдэх энэ шатлалыг бид тухайн үеийн хэлэлцээрт оруулсан.

Тэгэхээр яг 34 хувийг орлуулахдаа энэ хэлэлцээрийн хүрээнд тусгай роялтигийн 5 хувь болон өсөн нэмэгдэх роялтигийн 9 хүртэлх хувийг бол давхар яригдсан байгаа.

Энэ гурав нийлээд 1.3 тэрбум долларын өгөөж энэ 80 хувь гэдэг энэ дефолт тооцоон дээр гарч байгаа. Энэ нь дүнгээрээ мөргөнө. Дээрээс нь бид энэ 20, 30 жил, нийт 50 жил хүртэл хэрэгжих энэ төсөл дээр бид хамгийн эрсдэлгүй өгөөж дээр суурилж байгаа.

Дараагийн асуудлын хувьд Ц.Даваасүрэн даргын хэлж байгаа зардал өсгөх энэ хувилбар хөрөнгө оруулагч талд ашигтай байх уу гэдэг. Оюу Толгойн бид

нарын сургамж бол зардал өсгөх нь ямар тохиолдолд хөрөнгө оруулагчид ашигтай байх вэ гэхээр тэд нар ногдол ашгаас.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Н.Учрал сайд нэмэх гээд байгаа юм уу?

Н.Учрал: Тийм. Ер нь ийм л юм байна лээ л дээ.

Төр 34 хувиа эзэмших дээр стратегийн ордууд дээр одоо хэлэлцээр хийж эхэлнэ. Ингээд хэлэлцээр хийхээр хувийн компаниуд юу гэж байгаа вэ гэхээр та нар 34 хувиа ав. Гэхдээ та нар хөрөнгө оруулна шүү. Та нар хариуцлагаа хүлээнэ шүү гэж байгаа юм.

Тэгэхээр бид юу тавьж байгаа вэ гэхээр бид байгалийнхаа баялгийг үнэлнэ.

Тэгэхээр энэ гэрээн дээр бид байгалийнхаа баялгийг үнэлсэн. Тэгээд бид 34-өө бүтнээр нь аваад өнөөдөр Оюу Толгой шиг жил болгон ногдол ашиг авах хугацаа нь хойшлоод байх тохиолдолд 46 хувь нь эрсдэлгүй орлого, нөгөө АМНАТ-аар орлуулж байгаа нь 18 хувь нь эрсдэлгүй орлого гэсэн ийм хоёр томъёолол гарч ирсэн.

Хэрвээ 34 хувиа ногдол ашгаа авъя гээд тооцоолох юм бол яг өнөөдөр харахад 55.6 сая долларын ашигтай, 34-ийг АМНАТ-аар орлуулахад 5.2 сая долларын ашигтай юм шиг яригдаж байгаа. Харахад. Гэхдээ ногдол ашиг авах хугацаа нь бүү мэд. Нөгөө талд зардлаа нэмнэ. Дээрээс нь бид хөрөнгө оруулна. Өр үүсэх юм бол, зээл үүсэх юм бол 34 хувь дээрээ хариуцлагаа хүлээнэ. Ингээд яваад эхэлнэ.

Тэгэхээр хамгийн эрсдэлгүй орлого нь юу юм бэ гэвэл ерөөсөө л борлуулалтаас нь АМНАТ авах юм байна гэж тооцоод нийт тооцоолол дээрээ харсан болохоос биш шууд автоматаар бүтнээр нь 24-ийг нь АМНАТ болгоё гээд тэд нарын бүх зардлыг нь оруулахгүйгээр шууд хил дээрээс нь, борлуулалтаас нь авна гэх юм бол хөрөнгө оруулалт гэж хэн энд хөрөнгө оруулах вэ дээ. Тэр ямар ч боломжгүй шүү дээ. Тэр чинь мэдээж зардал гарна. Гэтэл дөнгөж ороод ирж байгаа борлуулалтаас нь 34-ийг нь авна гэвэл 34 хувийн АМНАТ авна гэсэн ойлголт наанаас чинь үүсэх байхгүй юу.

Тэгэхээр тэрийг 5-аар орлуулна гэдэг нь эрсдэл нь бага. Дээрээс нь бид хариуцлага хүлээхгүй гэдгээрээ эцсийн үр дүндээ 2028 оноос ногдол ашгаа авна л гэдэг.

Ц.Даваасүрэн: Ер нь яах вэ. Харин тэр баялгаа үнэлнэ гээд. Бид чинь баялгаараа хөрөнгө оруулалт хийж байгаа гэдгээ л монголчууд минь нэг ойлгох хэрэгтэй байгаа юм даа.

Ерөөсөө баялгаа тооцохгүй байна шүү дээ. Бид баялгаараа хөрөнгө оруулалт хийж байна. Та нар үйлдвэрээрээ хөрөнгө оруулалт хий гэдэг юмыг ярихгүй явсаар байгаад өнөөдөр хүрлээ шүү дээ.

Тэгээд одоо харин энэ төсөл дээр ярьж байгаа нь зөв. Бид чинь баялгаа гаргаж байгаа байхгүй юу. Тэд нар үйлдвэрээ гарга. Нөгөө талаараа баялгийг эзэмшиж байгаа хүн баялгийг хайж олж байгаа хүнээсээ бага хувь эзэмшиж байгаа. Үүнийг бид яваандаа засах хэрэгтэй. Яаж ч бодсон байна шүү дээ баялгийг эзэмшиж байгаа хүнээс баялгийг хайж олсон хүн илүү хувь эзэмшдэг байж болохгүй шүү дээ. Үүнийг л ашигт малтмалын хуулиас бид өөрчлөхгүй бол энэ 34 хувь гэсэн энэ нэг балай юм чинь одоо ингээд л гай болоод л.

Тэр 34 хувьд хөрөнгө оруулалтаар хариуцлага хүлээнэ гэдэг юм бол угаасаа бид мартаж хэрэгтэй. Бид баялгаа гаргаж байгаа. Баялгаараа бид хувиа авах ёстой. Үнэгүй авах ёстой.

Ингээд “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээ орлуулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж.

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Зарчмын зөрүүтэй санал гаргах юм байна. Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал гаргаж болно.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал хэлэлцэж дууссан тул хуралдааныг хаалаа. /алх цохив/

Баярлалаа гишүүд ээ.

Хуралдаан 50 минут үргэлжилж, 11 цаг 20 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД